



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 2021 ОНЫ ОРОН НУТГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2022/02/НА-СТА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
даржаах хэлтсээр авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsuronu@audit.gov.mn

Аудитор Н.Отгонцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

АГУУЛГА

Тайлан баталгаажуулсан тушаал	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товьёг	4
Дүрслэлийн товьёг	4
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТААР ОРЛОГО, ЗАРЛАГЫГ НЭМЭГДҮҮЛСЭН НЬ ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛГҮЙ ХИЙГДСЭНИЙГ ХАРУУЛЖ БАЙНА.....	7
<i>А.1. Төсвийн орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн байна</i>	<i>7</i>
<i>А.1.1 Аймгийн төсвийн нийт орлогыг төсвийн төсөлд үндэслэн 27,521.9 сая төгрөгөөр баталжээ.....</i>	<i>7</i>
<i>А.1.2 Төсөвт зохицуулалт хийхдээ тооцоо, судалгаагүйгээр орлогыг 3,428.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.....</i>	<i>7</i>
<i>А.2. Төлөвлөлтийг үндэслэлгүй хийснээс төсвийн зохицуулалтаар орон нутгийн зарлагыг нэмэгдүүлжээ.....</i>	<i>9</i>
<i>А.2.1. Төсөвт зохицуулалт хийхдээ зарлагыг нийт 3,766.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.....</i>	<i>9</i>
<i>А.2.2. Хуульд заасны дагуу төсөвт тодотгол хийж, нийт зарлагыг 749.8 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ</i>	<i>11</i>
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО 12.0 ХУВИАР ДАВСАН БАЙНА.....	12
<i>Б.1 Орон нутгийн төсвийн орлого 112.0 хувиар биелжээ.....</i>	<i>12</i>
<i>Б.1.1 Төсвийн орлогын төлөвлөгөө 3,785.1 сая төгрөгөөр давж биелсэн байна.....</i>	<i>12</i>
<i>Б.1.2 Тусламж, санхүүжилтийн орлого 88.8 хувийн гүйцэтгэлтэй байна</i>	<i>12</i>
<i>Б.2. Орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр бүрэн биелүүлсэн байна</i>	<i>13</i>
<i>Б.2.1 Аймгийн төсвийн орлого 10.6 хувиар давж, нэр төрлөөр бүрэн биелжээ.....</i>	<i>13</i>
<i>Б.2.2 Сумдын төсвийн орлого 16.2 хувиар давсан боловч зарим нэр төрлийн орлого тасарчээ</i>	<i>14</i>
БҮЛЭГ 3. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	16
<i>В.1. Урсгал зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй зарцуулжээ.....</i>	<i>16</i>
<i>В.1.1. Орон нутгийн төсвийн байгууллагууд урсгал зардлыг 9.9 хувиар буюу 1,970.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна</i>	<i>16</i>
<i>В.1.2 Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулжээ</i>	<i>17</i>
<i>В.2. Төсвийн жилийн дундуур хөрөнгийн зардлыг нэмэгдүүлснээс хөрөнгийн зардлын гүйцэтгэл 52.8 хувьтай гарчээ</i>	<i>18</i>
<i>В.2.1. Хөрөнгийн зардлаас 9,549.6 сая төгрөг зарцуулаагүй байна.....</i>	<i>18</i>
<i>В.2.2. Сумдын СХС-аас нийт 492.4 сая төгрөгийн зээл олгож, 66.3 хувийн гүйцэтгэлтэй байна</i>	<i>18</i>
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал.....	19
Тайланд тусгасан тэмдэглэл	21
ДҮГНЭЛТ:.....	23
ЗӨВЛӨМЖ:.....	23

Тайлан баталгаажуулсан тушаал



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 4/06

Дархан сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу "Дархан-Уул аймгийн 2021 оны орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргалд хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргалд зөвлөсүгэй.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн дотор архивын нэгж болгон Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /аудитор Н.Отгонцэцэг/-т үүрэг болгосугай.

5. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /У.Батсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ш.МӨНХБАЯР

003010013

D:\Бичиг хэрэг\TUSHAAL.docx

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НААУГ	Нийтийн аж ахуй үйлчилгээний газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
СХС	Сум хөгжүүлэх сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УИХ	Улсын Их Хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ЭМД	Эрүүл мэндийн даатгал



Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Орлогын төсвийн төсөл, батлагдсан төсөв	6
Хүснэгт №2	Төсвийн орлогын батлагдсан төлөвлөгөө	7
Хүснэгт №3	Батлагдсан төсөв	9
Хүснэгт №4	Төсвийн зарлагын тодотгол	10
Хүснэгт №5	Төсвийн орлогын гүйцэтгэл	11
Хүснэгт №6	Тусламж санхүүжилтийн орлогын гүйцэтгэл	11
Хүснэгт №7	Аймгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	12
Хүснэгт №8	Сумдын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	13
Хүснэгт №9	Төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл	15
Хүснэгт №10	Урсгал зардлын гүйцэтгэл	15
Хүснэгт №11	Нэмэлт санхүүжилт	16

Дүрслэлийн товьёг


№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	Аймгийн ТЕЗ-ийн нийт зарлагын төлөвлөлт	9
Дүрслэл №2	СХС-аас олгосон зээл	17

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын төлөвлөгөө батлах тухай” 2022 оны А/12 дугаар тушаал, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Дархан-Уул аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлж, зарлага үр дүнтэй зарцуулагдсан эсэхийг шалгаж, дүгнэлт гарган, аймгийн удирдлагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх; • Төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх; • Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх;
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитыг Дархан-Уул аймгийн орон нутгийн төсөв, ТЕЗ-ийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.</p>
<p>Аудитын хязгаарлалт</p>	<p>.....</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3100, Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах шалгагдагч байгууллагаас авсан бүх төрлийн нотлох зүйлсийг нягтлан шалгаж, нөхцөл байдлын шинжилгээ хийж, аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр хянан удирдаж, аудитыг ахлах аудитор У.Батсүрэн, аудитор Н.Отгонцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэв.</p>
<p>Хүндрэл бэрхшээл</p>	<p>.....</p>

Ерөнхий мэдээлэл

Дархан-Уул аймгийн 2021 оны татварын ба татварын бус орлого, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдсэн эх үүсвэрийг орон нутгийн төсвийн 26, тусгай зориулалтын 77 байгууллага, орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, замын сан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ зэрэг зардлыг санхүүжүүлэхээр нийт 86,350.8 сая төгрөгийн орлого төлөвлөж, гүйцэтгэлээр 73,805.4 сая төгрөг зарцуулжээ.

Аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн нийт орлого, зарлагыг аймгийн ИТХ-ын 2020 оны 2/02 дугаар тогтоолоор 77,216.0 сая төгрөг баталж, төсвийн зохицуулалтаар 3,428.9 сая төгрөгөөр нэмж, төсвийн тодотголоор 1,192.5 сая төгрөгөөр бууруулан баталсан бөгөөд төсвийн нийт орлогын гүйцэтгэл 97.2 хувь, зарлагын гүйцэтгэл 85.5 хувьтай гарсан байна.



БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТААР ОРЛОГО, ЗАРЛАГЫГ НЭМЭГДҮҮЛСЭН НЬ ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛГҮЙ ХИЙГДСЭНИЙГ ХАРУУЛЖ БАЙНА

А.1. Төсвийн орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн байна

А.1.1 Аймгийн төсвийн нийт орлогыг төсвийн төсөлд үндэслэн 27,521.9 сая төгрөгөөр баталжээ

Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн аймгийн 2021 оны төсвийн орлогын төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Дархан-Уул аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 25,402.4 сая төгрөгөөр баталсныг Дархан-Уул аймаг 2,086.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

Хүснэгт №1

Орлогын төсвийн төсөл, батлагдсан төсөв (сая төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	Төсвийн төсөл	ИТХ-ын баталсан төсөв /2020.12.04/	Зөрүү	
					ХБГ-ээс	Төсвийн төслөөс
	Орон нутгийн төсвийн суурь орлого	20,157.0	27,488.7	27,521.9	7,364.9	33.2
1	Татварын орлого	18,067.6	25,278.0	25,249.0	7,181.4	(29.0)
1.1	ХХОАТатвар	15,628.5	21,893.8	21,900.4	6,271.9	6.6
1.2	ХХОАТ-ын буцаалт	(1,583.5)	(2,407.5)	(2,407.5)	(824.0)	-
1.3	Хөрөнгийн албан татвар	2,268.7	2,314.4	2,308.3	39.6	(6.1)
1.4	Бусад татвар	1,753.9	3,477.3	3,447.8	1,693.9	(29.5)
2	Татварын бус орлого	2,089.4	2,210.7	2,272.9	183.5	62.2
2.1	Хүү, торгуулийн орлого	1,656.0	1,537.0	1,576.0	(80.0)	39.0
2.2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	161.6	129.0	162.2	0.6	33.2
2.3	Бусад орлого	271.8	544.7	534.7	262.9	(10.0)

Хүснэгтээс харахад аймгийн ИТХ-ын 2020 оны 2/02 дугаар тогтоолоор аймгийн төсвийн орлогыг батлахдаа өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 7,364.9 сая, төсвийн төслөөс 33.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Мөн ТЗШ-ийн орлогоос 38,786.5 сая, ЭМД-ын сангаас 179.8 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 8,430.4 сая, ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлогоос 125.1 сая, урьд оны үлдэгдлээс 1,467.7 сая, нийт 48,989.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, улсын төсөвт 2,686.4 сая төгрөг төвлөрүүлэхээр баталжээ.

А.1.2 Төсөвт зохицуулалт хийхдээ тооцоо, судалгаагүйгээр орлогыг 3,428.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна

Төсвийн жилийн дундуур Монгол Улсын Их Хурлын 2021 оны 7 дүгээр сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тодотгол хийхдээ Дархан-Уул аймгийн 2021 оны орон нутгийн төсвийн орлогод өөрчлөлт оруулаагүй байна. Харин тайлант онд аймгийн ИТХ-ын тогтоолоор төсвийн суурь орлогод 4 удаа өөрчлөлт оруулжээ.

Төсвийн орлогын батлагдсан төлөвлөгөө (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	АИТХ-ын 2020 оны 2/02 дугаар тогтоол	АИТХ-ын 2021 оны 01 дүгээр тогтоол	АИТХ-ын 2021 оны 02 дугаар тогтоол	АИТХ-ын 2021 оны 03 дугаар тогтоол	АИТХ-ын 2021 оны 11 дүгээр тогтоол
Орон нутгийн төсвийн орлого	28,699.7	28,226.7	29,226.7	32,655.3	31,463.2	31,463.2
Татварын орлого	25,316.3	25,249.0	26,249.0	29,671.6	27,773.6	27,773.6
ХХОАТатвар	21,399.2	21,900.4	21,900.4	25,323.0	22,790.0	23,533.2
ХХОАТ-ын буцаалт	(1,583.5)	(2,407.5)	(1,407.5)	(1,407.5)	(1,273.5)	(1,273.5)
Хөрөнгийн албан татвар	2,484.2	2,308.3	2,308.3	2,308.3	2,388.3	2,388.3
Бусад татвар /төлбөр хураамж/	3,016.4	3,447.8	3,447.8	3,447.8	3,868.8	3,125.6
Татварын бус орлого	3,383.4	2,977.7	2,977.7	2,983.7	3,689.6	3,689.6
Хүү, торгуулийн орлого	1,985.8	1,576.0	1,576.0	1,576.0	2,252.2	2,252.2
Төсвийн байгууллагын өөрийн орлого	266.9	162.2	162.2	168.2	133.9	133.9
Бусад орлого	349.9	534.7	534.7	534.7	594.7	594.7
СХС-ийн орлого	780.8	704.8	704.8	704.8	708.8	708.8

Дээрх хүснэгтээс харахад аймгийн ИТХ-ын 2021 оны 11 дүгээр тогтоолоор төсвийн орлогыг анх баталсан төсвөөс 3,236.5 сая, өмнөх оны гүйцэтгэлээс 2,763.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тодотгожээ.

Тайлант онд ХХОАТ-ын орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс 2,134.0 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн нь УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор иргэдийн орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах зорилгоор цалин хөлсний орлогод ногдох ХХОАТ-ыг чөлөөлсөнтэй холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 1 дүгээр тогтоолоор баталсан төсвийн зохицуулалтаар ХХОАТ-ын буцаалтыг 1,000.0 сая төгрөгөөр бууруулснаас төсвийн орлого энэ дүнгээр нэмэгдсэн бол 2021 оны 02 дугаар тогтоолоор төсөвт зохицуулалт хийхдээ цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 3,422.6 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 6.0 сая, нийт 4,428.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Харин 2021 оны 03 дугаар тогтоолоор цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 2,533 сая төгрөгөөр бууруулсан нь орлогыг тооцоо, судалгаагүйгээр нэмсэнтэй холбоотой гэж дүгнэлээ.

Төсвийн зохицуулалтаар цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг үндэслэлгүй, тооцоо судалгаагүйгээр нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2¹, 27 дугаар зүйлийн 27.1.2², 42.2³, 42.2.1а⁴, 42.2.1б⁵, дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Мөн Сангийн сайдын ТЕЗ-ийн 2021 оны төсвийн төсөл боловсруулах удирдамжид Малын тоо толгойн албан татварын тухай хууль батлагдсаны дагуу албан татварын хэмжээг тогтоож, сум дүүргийн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасны дагуу зарцуулахыг чиглэл болгосон байна. Сумдын ИТХ-ын тогтоолоор “Малын тоо

¹ жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх

² макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх

³ төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно

⁴ өөрийн төсийн багцад хамаарах хөтөлбөр хооронд

⁵ түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөв хооронд

толгойд албан татварын хэмжээг тогтоох тухай” шийдвэр гаргасан ч 2021 оны орлогын төлөвлөгөөнд тусгаагүй тул төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлөвлөгөөнд тусгаж, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болон зарцуулалтад төлөвлөх зөвлөмжийг хүргүүлжээ.

А.2. Төлөвлөлтийг үндэслэлгүй хийснээс төсвийн зохицуулалтаар орон нутгийн зарлагыг нэмэгдүүлжээ

А.2.1. Төсөвт зохицуулалт хийхдээ зарлагыг нийт 3,766.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна

Улсын Их Хурлын баталсан Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд Дархан-Уул аймгийн орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,686.4 сая, 17 дугаар зүйлд ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 7,405.0 сая, ОНХС-аас санхүүжих урсгал зарлагыг 1,025.1 сая төгрөгөөр тус тус баталсан байна.


Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас гаргасан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжид урсгал зардлын оновчтой хуваарилалт хийж, тэвчиж болох зардлыг бууруулах, цалин хөлсний зардлын төлөвлөлт болон гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ гэж тодорхойлжээ. Энэ хүрээнд аймгийн ТЭЗ төсвийн саналаа урьдчилан тооцсон суурь зарлагаас 11,718.8 сая, 2020 оны ХБГ-ээс 7,917.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 28,985.1 сая төгрөгөөр төсөвлөснийг Сангийн яам 17,472.8 сая төгрөгөөр хянасан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 2/02 тогтоолоор 2021 оны орон нутгийн төсвийн зарлагыг орлогын эх үүсвэрт тулгуурлан Сангийн яамны хянасан дүнгээс 4,855.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 22,328.0 сая төгрөгөөр баталсан нь өнгөрсөн оны зарлагаас 976.8 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-д суудалтай намд олгох дэмжлэгийг 2 дахин нэмж 165.0 сая,
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг 96.4 сая,
- Аймгийн ИТХ-ын 2019 оны 107 дугаар тогтоолоор “Дархан дахин төлөвлөлт” ОНӨААТҮГ байгуулснаар санхүүгийн дэмжлэгийг 70.7 сая,
- “Дархан орон нутгийн зам, тээвэр” ОНӨААТҮГ-ын орлого төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотойгоор санхүүгийн дэмжлэгийг 312.5 сая,
- СӨБ, ЕБС-ийн байгууллагыг хэвийн ажиллахаар тооцож, тогтмол зардал, эд хогшил, урсгал зардлыг 695.8 сая,
- Шинээр байгуулагдсан Ахмад хөгжлийн төвийн урсгал зардлыг 250.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь тайлант оны орон нутгийн төсвийн зарлага өнгөрсөн оны батлагдсан төсвөөс өсөхөд нөлөөлсөн байна.

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд ТЗШ-ээс 38,786.4 сая, ЭМД-ын сангаас 179.8 сая төгрөгийн санхүүжилт авахаар, боловсролын байгууллагын өөрийн орлогоос 125.1 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн ТЕЗ-ийн нийт зарлагын төлөвлөлт (сая төгрөгөөр)



Аймаг, сумдын ИТХ-аар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 4,712.7 сая, сумдын СХС-ийн зээл, түүнтэй холбоотой зардлыг 717.3 сая төгрөгөөр тус тус төлөвлөж, аймгийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 77,216.0 сая төгрөгөөр баталжээ.

ТЕЗ төсөвт нийт 3 удаа зохицуулалт хийхдээ урьд оны үлдэгдэл 4,618.6 сая төгрөгийг нэмэгдүүлснээс гадна орон нутгийн төсвийн зарлагыг нийт 3,766.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт №3

Батлагдсан төсөв (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Батлагдсан төсөв			Өөрчлөлт	
	Анх	Зохицуулалт 1	Зохицуулалт 2	Зохицуулалт 1	Зохицуулалт 2
Урсгал зардал	64,165.4	65,130.1	65,238.9	964.7	1,073.5
БАУ-ний зардал	54,984.2	56,278.4	56,223.5	1,294.2	1,239.3
Татаас	3,632.7	3,632.7	3,632.7	-	-
Урсгал шилжүүлэг	5,548.5	5,219.0	5,382.7	(329.5)	(165.8)
Хөрөнгийн зардал	12,360.8	17,014.7	19,672.3	4,653.9	7,311.5
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	689.8	689.8	689.8	-	-
ДҮН	77,216.0	82,834.5	85,601.0	5,618.5	8,385.0

Зохицуулалтаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 55 төсөл, арга хэмжээнд нийт 6,665.1 сая төгрөг зарцуулахаар нэмж баталсан нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2⁶ 42.4⁷, 42.7⁸, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 2.1⁹-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Мөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд тусгай сонирхлын болон спорт аялал жуулчлал зохион байгуулах, нарны эрчим хүчээр ажилладаг хөргөгч худалдан авахад нийт 9.7 сая төгрөг төлөвлөжээ. Энэ нь

⁶ Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно:

42.2.1 төсвийн ерөнхийлөн захирагч нь:

42.2.1.а өөрийн төсвийн багцад хамаарах хөтөлбөр хооронд;

42.2.1.б түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөв хооронд;

42.2.1.в төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчдын төсөв хооронд;

42.2.1.г түүнд шууд харьяалагдах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд.

42.2.2 төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд;

42.2.3 төсвийн шууд захирагч нь зөвхөн өөрийн урсгал зардалд.

⁷ Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна

⁸ Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгаадаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

⁹ Төсвийн захирагч дор дурдсан нөхцөлд батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж болно:

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” 3-т заасан арга хэмжээтэй нийцэхгүй байна.

А.2.2. Хуульд заасны дагуу төсөвт тодотгол хийж, нийт зарлагыг 749.8 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,039.9 сая төгрөгөөр бууруулж, 1,646.5 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 246.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 7,651.1 сая төгрөгөөр тус тус тодотгосон бол ОНХС-аас санхүүжих урсгал зарлагад өөрчлөлт оруулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-д заасны дагуу аймгийн ТЭЗ 2021 оны орон нутгийн төсвийн зарлагыг Сангийн яамны хянасан дүнгээс 2,611.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, өмнөх төсвөөс 158.3 сая төгрөгөөр бууруулж, 23,550.7 сая төгрөгөөр тодотгожээ.

Хүснэгт №4

Төсвийн зарлагын тодотгол (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Батлагдсан төсөв		Зөрүү
	Өмнөх	Тодотгол	
Суурь зарлага	23,709.0	23,550.7	(158.3)
ТЗШ	38,429.1	40,076.5	1,647.4
ОНХС	8,114.1	8,360.2	246.1
Хөрөнгө оруулалт	11,590.2	11,946.9	356.7
Улсын төсөвт төвлөрүүлэх	3,041.3	1,646.5	(1,394.8)
СХС	717.3	770.0	52.7
ДҮН	85,601.0	86,350.8	749.8

Монгол Улсын 2021 оны төсөвт тодотгол хийсэнтэй холбоотойгоор аймгийн ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 246.1 сая, ТЗШ-ийн байгууллагын зардлыг 1,647.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол улсын төсөвт төвлөрүүлэх

шилжүүлгийг 1,394.8 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Цар тахал гарч хөл хорио тогтоосонтой холбоотойгоор нийтийн тээврийн алдагдалд олгох татаасыг 230.0 сая, боловсролын байгууллагын тогтмол болон урсгал зардлыг 212.1 сая төгрөгөөр тус тус бууруулж, давсан орлогын дүнгээр хөрөнгө оруулалт, СХС-ийн зарлагыг нэмэгдүүлжээ.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО 12.0 ХУВИАР ДАВСАН БАЙНА

Б.1 Орон нутгийн төсвийн орлого 112.0 хувиар биелжээ

Б.1.1 Төсвийн орлогын төлөвлөгөө 3,785.1 сая төгрөгөөр давж биелсэн байна

Нэгдсэн төсвийн суурь орлого 35,248.6 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 3,785.1 сая төгрөгөөр буюу 12.0 хувиар давж биелсэн байна. Үүнд татварын орлого 2,845.3 сая төгрөгөөр буюу 10.2 хувь, татварын бус орлого 939.8 сая төгрөгөөр буюу 25.5 хувиар тус тус давж биелснээс шалтгаалжээ.

Хүснэгт №5
Төсвийн орлогын гүйцэтгэл (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2021 он		Зөрүү	
	Төл	Гүйц	Дүн	Хувь
Татварын орлого	27,773.9	30,619.2	2,845.3	110.2
Татварын бус орлого	3,689.6	4,629.4	939.8	125.5
Нийт дүн	31,463.5	35,248.6	3,785.1	112.0

Төсвийн орлого нийт дүнгээр 112.0 хувиар биелэхэд орлогын албан татвар 1,480.8 сая, өмчийн татвар 540.3 сая, төлбөр хураамж 755.4 сая, СХС-ийн зээлийн эргэн төлөлт

210.3 сая, хүү торгууль 449.3 сая төгрөгөөр тус тус давж биелсэнтэй холбоотой. Орлогын төлөвлөгөө давж биелэхэд дараах орлогууд нөлөөлжээ. Үүнд:

- Орлогын албан татварын орлого: Гүйцэтгэлээр цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 628.4 сая, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн өсөлттэй холбоотойгоор хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 415.8 сая, хадгаламжийн хүүгийн орлого 352.4 сая,
- Өмчийн татварын орлого: Өмнөх оны авлагаас 173 иргэн, ААНБ-ын 470.5 сая төгрөгийн татвар тайлант онд төсөвт төвлөрснөөр 485.7 сая,
- Төлбөр хураамжийн орлого: Тайлант оны эцэст хийсэн төсвийн зохицуулалтаар орлогыг хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн 742.9 сая төгрөгөөр бууруулснаас газрын төлбөрийн орлого, байгалийн нөөц ашигласны төлбөр нийт 755.4 сая,
- Хүү, торгуулийн орлого: “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн дагуу автомашины торгох шийтгэлийн төлбөрийг 50 хувь чөлөөлснөөр цагдаагийн газрын хүү торгуулийн орлогыг 388.7 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

Б.1.2 Тусламж, санхүүжилтийн орлого 88.8 хувийн гүйцэтгэлтэй байна

Аймгийн орон нутгийн тусламж, санхүүжилтийн орлогыг 54,887.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс 48,752.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь урьд оны үлдэгдэл 6,135.0 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой.

Хүснэгт №6

Тусламж, санхүүжилтийн орлогын гүйцэтгэл (сая төгрөгөөр)

Орлогын нэр төрөл	2021 он			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ОНХС-ийн орлогын шилжүүлэг	8,675.8	8,675.8	0.0	100.0
Тусгай зориулалтын шилжүүлэг	39,789.5	39,789.5	0.0	100.0
ЭМД-ын сангаас санхүүжих	179.8	162.3	(17.5)	90.2
ТЗШ-ийн байг-ын өөрийн орлого	107.2	124.9	17.7	116.5
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,135.0	0	(6,135.0)	-
ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	54,887.3	48,752.5	(6,134.8)	88.8

Хүснэгтээс харахад аймгийн ОНХС, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого батлагдсан төсвөөр буюу 48,465.3 сая, зардлын гүйцэтгэлд үндэслэн ЭМД-ын сангийн санхүүжилт 90.2 хувь буюу 162.3 сая, ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлогоос 116.5 хувь буюу 124.9 сая төгрөг тус тус төвлөрч, урьд оны үлдэгдэл 6,135.0 сая төгрөгийг тайлант онд зарцуулаагүй байна.

Б.2. Орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр бүрэн биелүүлсэн байна

Б.2.1 Аймгийн төсвийн орлого 10.6 хувиар давж, нэр төрлөөр бүрэн биелжээ

Аймгийн төсвийн орлого 25,788.0 сая төгрөгт хүрч гүйцэтгэл 110.6 хувиар биелснээс татварын орлого 1,769.0 сая, татварын бус орлого 705.7 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

Хүснэгт №7

Аймгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Өмнөх оноос	Төлөв-с
Татварын орлого	18,889.8	21,208.6	22,977.6	4,087.8	1,769.0
Цалин хөлс, урамшуулал	16,273.9	18,469.7	19,098.3	2,824.4	628.6
ХХОАТ-ын буцаалт	(1,583.5)	(1,273.5)	(1,273.5)	310.0	-
Хөрөнгийн албан татвар	2,466.0	2,292.4	2,846.9	380.9	554.5
Бусад татвар	1,733.4	1,720.0	2,305.9	572.5	585.9
Татварын бус орлого	2,302.8	2,104.7	2,810.4	507.6	705.7
Хүү, торгуулийн орлого	1,773.3	1,500.0	1,941.9	168.6	441.9
Төсвийн байгууллагын өөрийн орлого	204.2	70.0	121.7	(82.5)	51.7
Бусад орлого	325.3	534.7	746.8	421.5	212.1
Нийт орлого	21,192.6	23,313.3	25,788.0	4,595.4	2,474.7

Төсвийн жилийн дундуур орлогыг 2,412.5 сая төгрөгөөр бууруулж тодотгосноос гүйцэтгэл 2,474.7 сая төгрөгөөр давж биелэхэд нөлөөлжээ.

Тайлант онд цалин, хөлс шагнал урамшууллын татварын орлого 628.6 сая, өмнөх онд төлөгдөөгүй 470.5 сая төгрөгийн авлага барагдсанаар үл хөдлөх хөрөнгийн албан татвар 485.7 сая, цагдаагийн газрын хүү торгуулийн орлого давснаар 441.9 сая, тодотголоор орлогын төлөвлөгөөг бууруулснаас газрын төлбөр 208.9 сая, дуудлага худалдааны орлого 256.7 сая төгрөгөөр тус тус давсан байна.

Мөн оны эцэст аймгийн төсөвт зохицуулалт хийж бусад татварын орлогыг 400.0 сая төгрөгөөр бууруулж, цалин хөлс, шагнал урамшууллын орлогыг 552.0 сая төгрөгөөр нэмснээс орлого нэр төрлөөр биелжээ.

Б.2.2 Сумдын төсвийн орлого 16.2 хувиар давсан боловч зарим нэр төрлийн орлого тасарчээ

Сумдын орлого нийт дүнгээр 1,321.6 сая төгрөгөөр буюу 116.2 хувиар давсан байна.

Хүснэгт №8

Сумдын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
					Өмнөх оноос	Төлөв-с
1	<i>Дархан сум</i>	6,229.2	6,348.5	7,431.3	1,202.1	1,082.8
	Татварын орлого	5,577.9	5,655.7	6,597.3	1,019.4	941.6
	Татварын бус орлого	651.3	692.8	834.0	182.7	141.2
2	<i>Шарын гол сум</i>	486.1	418.1	474.3	(11.8)	56.2
	Татварын орлого	340.7	292.4	313.1	(27.6)	20.7
	Татварын бус орлого	145.4	125.7	161.2	15.8	35.5
3	<i>Хонгор сум</i>	602.9	1,143.1	1,269.3	666.4	126.2
	Татварын орлого	402.6	465.4	547.9	145.3	82.5
	Татварын бус орлого	200.3	677.7	721.4	521.1	43.7
4	<i>Орхон сум</i>	188.9	240.3	296.7	107.8	56.4
	Татварын орлого	105.3	151.5	183.3	78.0	31.8
	Татварын бус орлого	83.6	88.8	113.4	29.8	24.6
	Нийт дүн	7,507.1	8,150.0	9,471.6	1,964.5	1,321.6

Сумдын төсвийн орлого өмнөх оноос 1,964.5 сая, батлагдсан төсвөөс 1,321.6 сая төгрөгөөр буюу 13-23 хувиар давж биелсэн бөгөөд орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлсэн нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар нь авч үзвэл:

❖ *Дархан сум:*

Сумын хэмжээнд орон нутгийн төсвийн орлого 7,431.3 сая төгрөгт хүрч орлогын төлөвлөгөө 17.1 хувиар буюу 1,082.8 сая төгрөгөөр давсан байна.

Сумын малын тоо толгойн албан татварын орлогыг төсөвт тусгаагүйгээс 30.9 сая, хадгаламжийн хүүгийн орлого 369.8 сая, үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөнөөр хөрөнгө борлуулсны орлого 402.7 сая, бусад орлого он дамжиж орж ирснээр 93.3 сая, өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөгөөг бууруулснаас хог хаягдлын үйлчилгээний хураамж 172.5 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

Дархан сум нь тайлант оны эцэст хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн төсвийн зохицуулалт хийснээр орлогын төлөвлөгөө давсан ч үйл ажиллагааны орлого 33.8 сая, газрын төлбөрийн орлого 85.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

❖ *Шарын гол сум*

Сумын орлогын төлөвлөгөө 56.2 сая төгрөгөөр буюу 113.4 хувиар давж биелжээ. Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөөг батлаагүйгээс 14.0 сая, орон сууцны үнэ нэмэгдсэнээр хөрөнгө борлуулсны орлогын татвар 12,9 сая, “Дулаан Шарын гол” ТӨХК-аас хог хаягдлын хураамжийн үлдэгдэл төлбөрийг татан төвлөрүүлснээр 8.5 сая, СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлснээр 37.0 сая төгрөгөөр тус тус давсан бол банкны хадгаламжийн дүн, хүү буурснаас хамааран хадгаламжийн хүүгийн орлого 21.4 сая төгрөгөөр тасарсан байна.

❖ *Хонгор сум*

Сумын хэмжээнд орлогын төлөвлөгөөг 223.8 сая төгрөгөөр буюу 119.3 хувиар давж биелсэн нь банкны хадгаламж өссөнөөс 7.5 сая, үйл ажиллагааны орлого 15.9 сая, урьд оны газрын төлбөрийн өрийг барагдуулснаар 22.9 сая, байгаль орчны яамнаас ойн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нэмэгдсэнээр 24.4 сая, СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлснээр 28.4 сая төгрөгөөр тус тус давсан нь нөлөөлжээ. Харин үл хөдлөх хөрөнгийн борлуулалт буурснаас хөрөнгө борлуулсны орлого 3.7 сая, малын тоо толгойн албан татварын орлого гүйцэтгэлээр 9.4 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

❖ *Орхон сум*

Орлогын гүйцэтгэл 56.4 сая төгрөг буюу 113.4 хувиар давж биелсэн нь малын тоо толгойн албан татварыг төлөвлөгөөгүйгээс 15.9 сая, өмнөх онд төлөгдөөгүй үйл ажиллагааны орлого төвлөрснөөр 7,9 сая, хүү торгуулийн орлого 9.0 сая, СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлснээр 16.2 сая төгрөг тус тус давж биелүүлжээ.

Харин банкны хадгаламжийн хүү буурснаас хадгаламжийн хүүгийн орлого 3.4 сая, газрын төлбөр бүрэн төлөгдөөгүйгээс 1.2 сая, ус рашааны нөөц ашигласны татвар 4.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

БҮЛЭГ 3. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

В.1. Урсгал зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй зарцуулжээ.

В.1.1. Орон нутгийн төсвийн байгууллагууд урсгал зардлыг 9.9 хувиар буюу 1,970.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна

Аймгийн орон нутгийн 2021 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд 86,350.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 73,805.4 сая төгрөг зарцуулж, зардлын гүйцэтгэл 85.5 хувьтай гарсан нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс 1,120.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9

Төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	
		Төлөв	Гүйц	2020 оны гүйц-ээс	Төлөв-өөс
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	72,685.3	86,350.8	73,805.4	1,120.1	(12,545.4)
Урсгал зардал	61,212.2	65,333.2	62,602.4	1,390.2	(2,730.8)
Хөрөнгийн зардал	10,742.7	20,275.1	10,710.6	(32.1)	(9,564.5)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	730.4	742.5	492.4	(238.0)	(250.1)

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн урсгал зардал 62,602.4 сая төгрөг буюу 95.8 хувийн гүйцэтгэлтэй гарч, өнгөрсөн оноос 1,390.2 сая төгрөгөөр өссөн бол хөрөнгийн зардал 10,710.6 сая төгрөг буюу 52.8 хувийн, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 492.4 сая төгрөг буюу 66.3 хувийн гүйцэтгэлтэй гарч өнгөрсөн оны гүйцэтгэлээс тус тус буурчээ.

Нийт урсгал зардлын гүйцэтгэлд улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг 2.6 хувийг эзэлж байгаа бол ТЗШ-ийн байгууллагын зардал 68.6 хувийг, орон нутгийн төсөвт байгууллагын зардал 28.8 хувийг тус тус эзэлж байна. Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын гүйцэтгэл 90.1 хувийн гүйцэтгэлтэй гарч, урсгал зардлыг 1,970.4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт №10

Урсгал зардлын гүйцэтгэл (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2021 он		Зөрүү
	Төлөв	Гүйц	
Урсгал зардал	65,333.2	62,602.5	(2,730.7)
БАУ-ний зардал	57,782.2	55,420.1	(2,362.1)
Татаас	3,442.1	3,302.0	(140.1)
Урсгал шилжүүлэг	4,108.9	3,880.4	(228.5)

Урсгал зардлын гүйцэтгэл 95.8 хувьтай гарч 2,730.7 сая төгрөг хэмнэгдсэн нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах, сул орон тоонд томилгоо хийхгүй байх, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж зардал гаргахгүй байх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Мөн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдэл 641.3 сая, “Дархан орон нутгийн зам, тээвэр” ОНӨААТҮГ-ын орлого дутуу төвлөрснөөс 154.3 сая, Соёлын хэлтсийн үйл ажиллагаа эхлээгүйгээс 46.3 сая, Аж үйлдвэр, технологийн паркийн үйл ажиллагаа зогссоноор 23.7 сая, ахмад хөгжлийн төв бүрэн ажиллаагүйгээс 79.7 сая төгрөгөөр орон нутгийн төсөв тус тус хэмнэгджээ.

Орон нутгийн төсвийн давсан орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх 1,646.5 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлж, оны эцэст ТЗШ-ийн байгууллагуудын зарцуулаагүй үлдэгдэл 286.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой нийт 233.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 22.6 сая төгрөгийн албан шаардлага, 205.7 сая төгрөгийн зөвлөмжийг өгсөн байна.

Төлбөрийн акт тогтоосон зөрчлийн 92 хувь нь холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс цалин, нэмэгдэл хөлсийг илүү буюу давхардуулан олгосон зөрчил байгаа бол албан шаардлагын 85.1 хувь нь тушаал шийдвэргүйгээр цалингийн зардлаас ажил олгогчийн төлөх НДШ-ыг гүйлгэн зарцуулсан, өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтанд төрийн албаны цалингийн сүлжээгээр цалинжуулсан зэрэг зөрчил эзэлж байна.

Мөн анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар гүйлгээ хийсэн 63.2 сая, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж тэмцээн уралдаан зохион байгуулахад 40.5 сая, тушаал шийдвэргүйгээр зардал хооронд шилжүүлэн зарцуулсан 27.0 сая төгрөгийн зөрчил байгууллагуудад нийтлэг илэрчээ.

Дээрх нийт алдаа зөрчлийн 76.1 хувийг орон нутгийн төсвийн, 23.9 хувийг ТЗШ-ийн байгууллагуудын алдаа зөрчил эзэлж байгаа бөгөөд цалин, нэмэгдэл хөлсийг зөрүүтэй тооцож олгосон 102.9 сая төгрөгийн зөрчил 57 байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланд гарсан байна.

В.1.2 Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулжээ

Төсвийн байгууллагуудад тайлант онд нэмэлт санхүүжилтээр 3,431.1 сая төгрөг төвлөрсөн нь өнгөрсөн оноос 104.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №11

Нэмэлт санхүүжилт (сая төгрөгөөр)

№	ТЕЗ-ийн ангилал	Санхүүжилт	Зарцуулалт	Үлдэгдэл
1	БШУ-ны сайд	241.1	227.9	13.2
2	БХБ-ын сайд	8.7	8.7	-
3	ХНХ-ын сайд	404.1	398.8	5.3
4	Эрүүл мэндийн сайд	1,613.8	1,592.3	21.5
5	Аймгийн ТЕЗ	1,163.4	802.0	361.4
	Дүн	3,431.1	3,029.7	401.4

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр төвлөрсөн орлогын 88.3 хувийг зарцуулснаас 3,013.7 сая төгрөгийн урсгал, 16.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулжээ.

Аймгийн ТЕЗ-ийн нэмэлт санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл нь “УБ-Дархан” замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын нөхөн олговрын 170.5 сая, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, “Орон нутагт нүхэн жорлонг хоргүйжүүлэх” төслийн 80.0 сая, соёл урлагийг хөгжүүлэх, соёлын биет өвийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх зардлын 15.0 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйл, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журмын хүрээнд зарцуулсан байна.

В.2. Төсвийн жилийн дундуур хөрөнгийн зардлыг нэмэгдүүлснээс хөрөнгийн зардлын гүйцэтгэл 52.8 хувьтай гарчээ

В.2.1. Хөрөнгийн зардлаас 9,549.6 сая төгрөг зарцуулаагүй байна

Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 123 төсөл, арга хэмжээнд 11,915.0 сая төгрөг баталж, гүйцэтгэл 47.0 хувьтай, ОНХС-ийн хөрөнгөөр нийт 144 төсөл арга хэмжээнд 8,360.2 сая төгрөг баталж, гүйцэтгэл 63.4 хувьтай байгаа нь төсвийн жилийн дундуур зохицуулалт хийж шинээр 55 төсөл, арга хэмжээнд 6,665.1 сая төгрөг нэмж баталснаас шалтгаалжээ.


Хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөгөөнөөс он дамжин хэрэгжих 41 төсөл арга хэмжээний 4,317.7 сая, тендерийн хэмнэлт 9.8 сая, гүйцэтгэгчид олгох баталгаат хугацааны барьцаа 247.3 сая, магадалшгүй ажлын зардал 16.5 сая, ажлын гүйцэтгэл болон бичиг баримт хангалтгүй, техник хяналтын зардал, зургийн үнэ, комисс хүлээн аваагүй зэрэг шалтгаанаар 1,721.1 сая, нийт 6,312.4 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

ОНХС-гийн 3,056.4 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл нь дараа онд дамжин хэрэгжих 21 төсөл арга хэмжээний 1,724.8 сая, гүйцэтгэгчид олгох баталгаат хугацааны барьцаа 76.6 сая, тендерийн хэмнэлт 2.3 сая, тендер зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй, коронавируст цар тахлын улмаас хил хаагдсанаас бараа, бүтээгдэхүүн нийлүүлэгдээгүй зэргээс шалтгаалжээ.

В.2.2. Сумдын СХС-аас нийт 492.4 сая төгрөгийн зээл олгож, 66.3 хувийн гүйцэтгэлтэй байна

Тайлант онд сумдын ТЕЗ нар СХС-аас олгох зээлийг нийт 742.4 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 492.4 сая төгрөг буюу 66.3 хувийг зарцуулсан нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс 238.0 сая төгрөгөөр буурчээ.

Дүрслэл №2



Хонгор сумын СХС-аас зээл олгоогүй нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 01/2191 тоот албан бичгээр зээл олгохгүй байх шийдвэр ирсэнтэй

холбоотой байна. Бусад сумдын хувьд дээрх хугацаанаас өмнө нийт 95 иргэн, ААНБ-д 492.4 сая төгрөгийн зээл олгожээ.

Сумдын СХС-ийн хугацаа хэтэрсэн зээл 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 66 иргэн, ААНБ-ын 280.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 50 зээлдэгчийн 226.4 сая төгрөгийг төлүүлэхээр хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал


МОНГОЛ УЛС
ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГА
40260 Дархан, Дархан-Уул аймаг
Утас: 7037-8023, Факс: 7037-7121
E-mail: info@darhan.gov.mn
Вебсайт: www.darhan.gov.mn

2022.04.20 № 1-10/265

Төрийн _____ -ийн № _____

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ш.МӨНХБАЯР ТАНАА

Аймгийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, хариуг хүргүүлэв.

ДАРГА  Б.АЗЖАРГАЛ

4522100553

0-ZDTG-2022 төр-1

2021 оны орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын
тайлангийн төсөлд өгөх санал

4/22/2022

№	Алдаа, зөрчлийн товч утга, зөвлөмж	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар
1	Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр төсөвт нийт 3 удаа зохицуулалт хийсэн байна.	Төсвийн тухай хуулийн 42.4- т дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөл авна гэж заажээ Энэ хуулийн 4.1.35-д "төсвийн захирагч гэж" төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчийг хэлнэ гэж заасан байна. Аймгийн хувьд төсвийн захирагч гэж 4.1.36 /өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг т/-д зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 2.2 дах хэсэгт заасны дагуу төсвийн зохицуулалт хийсэн болно.
2	Төсөвт зохицуулалт хийхдээ зарлагыг нийт 3766.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.	Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг авах эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор Засаг даргын нөөц хөрөнгө болон аймгийн ИТХ-ын төсвийг ажлын албаны бүтэц шинэчлэн батлагдсан болон аймгийн 60 жилийн ойн арга хэмжээ, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээг нэмсэн нь төсвийн тухай хуулийн 64.1, 14.3, квидын тухай хуулийн 7.1.2-т /цар тахлын үед шаардлагатай арга хэмжээ авах санхүүжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарын тухайн жилийн батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар эх үүсвэр бүрдүүлэх/ гэж заасан, Сангийн сайдийн 2021 оны 56, 2018 оны 134-р тушвалыг баримтлан хийгдсэн.
4	Орон нутгийн орлогыг төлөвлөхдөө боломжит эх үүсвэр, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, төсвийн зохицуулалтаар орлогын нэр төрөл, батлагдсан төсвийн нийт дүнд өөрчлөлт оруулахгүй байх	Төсвийн тухай хуулийн 42.2 -т орлогын зохицуулалт бас хамгаарна. Төсвийн зохицуулалтаар орлогын нэр төрөл, батлагдсан төсвийн нийт дүнд өөрчлөлт оруулахгүй байх гэсэн хэсгийг хасуулах саналтай байна.

Тайланд тусгасан тэмдэглэл

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛЫГ
ТАЙЛАНД ТУСГАСАН ТЭМДЭГЛЭЛ

№	Холбогдох байгууллагын санал	Тайлбар
1	<p>Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 нь дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөл авна гэж заажээ. Энэ хуулийн 4.1.35-д "төсвийн захирагч гэж" төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчийг хэлнэ гэж заасан байна. Дархан-Уул аймгийн хувьд төсвийн захирагч гэж 4.1.36 /өврийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөөлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг т/-д зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч болно.</p>	<p>Төсвийн тухай хуулийн 4.1.36-д зааснаар аймгийн Засаг дарга ТЭЗ боловч хуулийн 42 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалд төсөвт зохицуулалт хийх нөхцөл шаардлагыг тодорхой заасан тул хэвээр үлдээв.</p>
2	<p>Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг авах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор 2021 оны эхний 5 сарын байдлаар 888 иргэнийг 9 ажиглан тусгаарлах бейранд байрлуулсан. Уг байруудын төлбөр болох 300.0 сая төгрөгөөр аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг, аймгийн ИТХ-ын төсвийг Ажлын албаны бүтэц шинэчлэн батлагдсан болон аймгийн 60 жилийн ой, Ардын хувьсгалын 100 жилийн ойн баяр наадмыг 2021 онд тэмдэглэн өнгөрүүлэх зэргээр 30.0 сая төгрөгөөр, аймгийн Залуучууд театрын үйл ажиллагааны зардлыг 86.0 сая төгрөгөөр нэмсэн нь Төсвийн тухай хуулийн 64.1, 14.3, Ковидын тухай хуулийн 7.1.2-т /цар тахлын үед шаардлагатай арга хэмжээ авах санхүүжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарын тухайн жилийн батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар эх үүсвэр бүрдүүлэх/ заасан, Сангийн сайдын 2021 оны 56, 2018 оны 134-р тушаалыг баримтлан хийгдсэн байна.</p>	<p>Сангийн сайдын 2021 оны "Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" 56 дугаар тушаалын 5 дугаар хэсгээр "2021 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын сар улирлын хуваарь"-ийг шинэчлэн баталсан нь зардлыг нэмэгдүүлэх үндэслэл болохгүй тул тайланд хэвээр үлдээв.</p>
3	<p>6 дугаар сарын төсвийн зохицуулалтаар цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 3,428.6 сая төгрөгөөр орлогын мэргэжилтэн, татварын хэлтэс нь орно гэж тооцож нэмэгдүүлсэн байна.</p>	<p>Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд төсөвт зохицуулалт хийх тухай тодорхой заасан бөгөөд орлогыг нэмэгдүүлэх тухай зүйл заалт тусгагдаагүй, мөн орлого нэмэгдүүлэх тооцро судалгаа, тайлбарыг ирүүлээгүй тул тайланд хэвээр үлдээв.</p>

4	<p>Төсвийн тухай хуулийн 42.2-т орлогын зохицуулалт бас хамаарна. Төсвийн зохицуулалтаар орлогын нэр төрөл, батлагдсан төсвийн нийт дүнд өөрчлөлт оруулахгүй байх гэсэн зөвлөмжийг хасуулах саналтай байна.</p>	<p>Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт ТЭЗ нь төсвийн бацад хамаарах хөтөлбөр хооронд, түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөв хооронд, төсвийн төвлөрүүлэн захирагч болон ТШЗ-дын төсөв хооронд, түүнд шууд харьяалагдах ТШЗ-дын төсөв хооронд төсвийн зохицуулалт хийж болно гэж заасан байна. Энэ нь орлогын төлөвлөгөөний нэр төрөл болон батлагдсан төсвийн нийт дүнд өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй тул тайланд зөвлөмжийг хэвээр үлдээв.</p>
---	---	--



 АХЛАХ АУДИТОР У. БАТСҮРЭН

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Төсөвт зохицуулалт хийхдээ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тогтоолыг зөрчиж, орон нутгийн орлогыг 3,428.6 сая, нийт зарлагыг 3,766.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, төсвийг үндэслэлгүй төлөвлөсөн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагч Б.Азжаргал, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Б.Жаргалсайхан нарт зөвлөх нь:

- Төсөвт зохицуулалт хийхдээ Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 2.1-д заасныг баримталж ажиллах
- Орон нутгийн орлогыг төлөвлөхдөө боломжит эх үүсвэр, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, төсвийн зохицуулалтаар орлогын нэр төрөл, батлагдсан төсвийн нийт дүнд өөрчлөлт оруулахгүй байх

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны дотор багтаан Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2022.04.20